



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 5/18

Чингис хот

О.Анхбатад сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1, 131.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын санхүүгийн бүртгэл тайлангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж, санхүүгийн тайлангын аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан Дэлгэрхаан сумын Засаг дарга О.Анхбатад сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Санхүүгийн тайланд бүртгэлээр тавих хяналтаа эрс сайжруулж ажиллахыг О.Анхбатад үүрэг болгосугай.

3. Энэхүү захиргааны актыг эс хүлээн зөвшөөрвөл албан ёсоор гардаж авсанаас хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА